



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

ТЕЛЕВИЗ, ОЛОН СУВАГ ДАМЖУУЛАХ ҮЙЛЧИЛГЭЭ ЭРХЛЭГЧДИЙН
ЗОХИОГЧИЙН ЭРХИЙН ЗӨВШӨӨРӨЛТЭЙ БҮТЭЭЛИЙН ЖАГСААЛТЫГ ИЛ ТОД
БАЙРШУУЛАХ WWW.COPYRIGHT.CRC.GOV.MN СИСТЕМИЙН АШИГЛАЛТ,
ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН



1. ТАНИЛЦУУЛГА: Харилцаа холбооны зохицуулах хороо (ХХЗХ) нь Харилцаа холбооны тухай хууль, Өргөн нэвтрүүлгийн тухай хууль болон бусад холбогдох хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд харилцаа холбоо, өргөн нэвтрүүлгийн зах зээлд үр ашигтай, шударга өрсөлдөх нөхцөл бүрдүүлэх, төрөөс баримталж байгаа бодлогын хэрэгжилтийг хангуулах, тусгай зөвшөөрөл олгох, мэргэжлийн дүгнэлт, шийдвэр гаргах чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Зохиогчийн эрхийн тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1-д “... өргөн нэвтрүүлгийн байгууллага, олон сувгийн дамжуулагч нь өөрийн болон бусад сервер, сүлжээ, санд зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн зөрчил гаргахгүй байх, зохиогчийн эрх болон хамаарах эрх эзэмшигчийг эрхээ хэрэгжүүлэх боломжоор хангах үүрэгтэй”, Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, хэт төвлөрөл үүсэхээс сэргийлэх журмын 2.8.3-т “албан ёсны эрхийг нь авсан контент, бүтээл, нэвтрүүлгийн жагсаалтыг өөрийн албан ёсны цахим хуудсанд байршуулах үүрэгтэй” гэж тус тус заасан байдаг.

ХХЗХ-ны зүгээс дээрх хууль, журмын хэрэгжилтийг хангуулах, өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, оюуны өмчийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 2023 онд “Телевиз, олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн зохиогчийн эрхийн зөвшөөрөлтэй бүтээлийн жагсаалтыг ил тод, нээлттэй байршуулах дундын нэгдсэн систем”-г <https://copyright.crc.gov.mn/> үүсгэн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Түүнчлэн ХХЗХ нь 2024 оны нэгдүгээр улиралд уг системд нэмэлт хөгжүүлэлт хийж олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн сүлжээгээр дахин дамжиж байгаа гадаад сувгийг бүртгэх бие даасан цэс үүсгэж, бүртгэлийг цахим хэлбэрт шилжүүлсэн.

ХХЗХ-ноос 2023 оны 4 дүгээр улиралд үйлчилгээ эрхлэгчдэд хүргүүлсэн албан бичгийн хүрээнд “Телевиз, олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн зохиогчийн эрхийн зөвшөөрөлтэй бүтээлийн жагсаалтыг ил, тод нээлттэй байршуулах дундын нэгдсэн систем”-д бүтээлийн мэдээллээ оруулах ажилчдын мэдээллийг авч телевиз, олон сувгийн үйлчилгээ эрхлэгч тус бүрд нэвтрэх эрхийг нь нээсэн.

2. СИСТЕМД МЭДЭЭЛЭЛ ОРУУЛСАН БАЙДАЛ: 2024 оны 2 дугаар улирлын байдлаар системд бүртгэлтэй 168 үйлчилгээ эрхлэгч (Арилжааны телевиз-55, олон сувгийн дамжуулах үйлчилгээ эрхлэгч (ОСДҮЭ)-31 байгаа бөгөөд үүнээс тусгай зөвшөөрлөө хүчингүй болгуулсан 2, идэвхтэй 29 үйлчилгээ эрхлэгч байгаа болно. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчид (ӨНТВ)-68, Төлбөртэй телевиз-16) байгаа бөгөөд дээрх үйлчилгээ эрхлэгчдийн 30 нь өөрийн бүтээлийг, 12 нь дотоодын бүтээлийг, 17 нь гадаадын бүтээлийн мэдээллийг тус тус системд бүртгүүлсэн байна. Системд бүртгэлтэй нийт бүтээлийн тоогоор нь авч үзэхэд 2111 бүтээл

бүртгэгдсэн ба үүнээс өөрийн бүтээл 651, дотоод бүтээл 446, гадаад бүтээл 1014 байна.

Зураг 1. Системийн бүртгэлийн мэдээлэл



Бүтээлийн мэдээллээ оруулсан үйлчилгээ эрхлэгчдийг үйлчилгээний төрлөөр нь авч үзэхэд өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгч-23, арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэгч-11, олон сувгийн дамжуулах үйлчилгээ эрхлэгч-6 байна. Системд бүртгүүлсэн бүтээлийн хэмжээг үйлчилгээний төрлөөр нь авч үзэхэд өргөн нэвтрүүлгийн телевизүүд системд 1362 бүтээл, арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэгч 489, олон сувгийн дамжуулах үйлчилгээ эрхлэгч 260 бүтээл тус тус бүртгүүлсэн бол төлбөртэй телевизийн үйлчилгээ эрхлэгчид нь бүтээл бүртгүүлээгүй байна.

Зураг 2. Өөрийн бүтээлээ системд оруулсан үйлчилгээ эрхлэгчдийг үйлчилгээний төрлөөр нь авч үзэхэд



2.1. ӨӨРИЙН БҮТЭЭЛ: Системд 30 үйлчилгээ эрхлэгчийн 651 өөрийн бүтээл бүртгэгдсэн нь нийт бүртгэгдсэн бүтээлийн 30.8%-ийг эзэлж байна. “Очир Арвай” ХХК-ийн Төв ТВ нь өөрийн бүтээлийн мэдээллийг хамгийн их оруулсан бөгөөд нийт 151 бүтээл оруулсан нь системд бүртгэлтэй өөрийн бүтээлийн 23.1%-ийг эзэлж байна. “Шинэ зураг” ХХК болон “Очир роуд” ХХК нь тус бүр нэг бүтээл оруулсан нь хамгийн бага буюу 0.1%-ийг эзэлж байна.




Хүснэгт 1. Үйлчилгээ эрхлэгчдийг системд бүртгүүлсэн өөрийн бүтээлийг авч үзэхэд, тоогоор

Системд бүртгүүлсэн өөрийн бүтээл	Үйлчилгээ эрхлэгчийн нэр
24	Юнивишн ХХК
33	Мобинет ХХК
40	Чаннел-Уан ХХК
6	Масс Ти Ви ХХК
6	Монгол телевиз ХХК
16	Нэйшл ньюс корпорэйшн ХХК
3	Суваг ти ви найм ХХК
10	Асгатын гол ХХК
3	Эн Ти Ви Бродкастинг ХХК
85	Медиа боловсрол суваг ХХК
35	АЭ энд Жааг ХХК
25	Фило ХХК
5	Хатрек ХХК
7	Медиа холдинг ХХК
60	Юнайтед бродкастинг корпорэйшн ХХК
10	Ай Жи Би Ти Виз ХХК
18	Мичид Ньюс ХХК
22	Мерөөдлийн суваг ТББ
7	Хас-Өрлөг ТББ
4	Ар Би Эм Ти ХХК
7	Маст технологи ХХК
1	Шинэ зураг ХХК
2	Эм Ди Энтертэймент ХХК
151	Очир Арвай төв ХХК
7	Лакс ТВ Монгол ХХК-натур хаан ххк
7	Натур хаан ХХК
19	Ийгл Бродкастинг ХХК
1	Очир роуд ХХК
31	Ашдын нөхөр ХХК
6	Улаанбаатар телевиз ХХК
651	Нийт

Өөрийн бүтээлийн мэдээллээ бүртгүүлсэн дээрх үйлчилгээ эрхлэгчдийг системд бүртгэлтэй 155 үйлчилгээ эрхлэгчдийн тоотой харьцуулахад 19%-тай байна.

График 1. Үйлчилгээ эрхлэгчдийн өөрийн бүтээлийг системд бүртгээдсэн нийт өөрийн бүтээлд эзлэх хувиар авч үзэхэд



Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн хувьд өөрийн бүтээл гаргаж хэрэглэгчдэд хүргэх нь телевизийн үйлчилгээ эрхлэгчдийг бодоход бага, үндсэн үйлчилгээ биш тул видео сангийн үйлчилгээ үзүүлэгч IPTV, OTT, хиймэл дагуулын технологиор олон суваг дамжуулах үйлчилгээг хүргэж байгаа үйлчилгээ эрхлэгчид



өөрийн видео сангийн үйлчилгээгээр дамжуулан өөрийн бүтээлээ хэрэглэгчдэд хүргэж байгаа цөөн тохиолдлууд байна. Жишээ нь: Юнивишн ХХК, Мобинет ХХК.

Телевизийн хөтөлбөрт тавигдах шаардлагын 3.4, 3.5 дахь заалтад өөрийн бүтээлийн хувь хэмжээг зааж, телевизийн үйлчилгээ эрхлэгчдэд үүрэг хүлээлгэсэн байдаг. Харин олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн хувьд үндсэн үйлчилгээ нь телевизийн олон сувгийг дамжуулан хэрэглэгчдэд хүргэх үйлчилгээ тул видео сангийн үйлчилгээтэй үйлчилгээ эрхлэгчдээс бусад нь өөрийн бүтээл гэж бүртгүүлэхгүй юм.

Хүснэгт 2. Өөрийн бүтээлийг хөтөлбөрийн төрлөөр нь үйлчилгээ эрхлэгч нэг бүрээр авч үзэхэд

№	Үйлчилгээ эрхлэгчийн нэр	Уран Сайхны кино	Олон ангит кино	Баримтат кино	Хүүхэдлэйн кино	Олон ангит хүүхэдлэйн кино	Нэвтрүүлэг	Богино хэмжээний кино	Бусад	Нийт
1	Юнивишн ХХК	14	8	1		1				24
2	Мобинет ХХК		21				12			33
3	Чаннел-Уан ХХК						40			40
4	Масс Ти Ви ХХК						6			6
5	Монгол телевиз ХХК						6			6
6	Нэйшнл ньюс корпорэйшн ХХК						16			16
7	Суваг ти ви найм ХХК						3			3
8	Асгатын гол ХХК						10			10
9	Эн Ти Ви Бродкастинг ХХК						3			3
10	Медиа боловсрол суваг ХХК		10				75			85
11	АЭ энд Жааг ХХК		1	1			32	1		35
12	Фило ХХК						25			25
13	Хатрек ХХК						4	1		5
14	Медиа холдинг ХХК						7			7
15	Юнайтед бродкастинг корпорэйшн ХХК								60	60
16	Ай Жи Би Ти Виз ХХК						10			10
17	Мичид Ньюс ХХК						18			18
18	Мөрөөдлийн суваг ТББ				1		20	1		22
19	Хас-Өрлөг ТББ			2			5			7
20	Ар Би Эм Ти ХХК						4			4
21	Маст технологи ХХК						7			7
22	Шинэ зураг ХХК						1			1
23	Эм Ди Энтертэймент ХХК						2			2
24	Очир Арвай төв ХХК						151			151
25	Лакс ТВ Монгол ХХК-натур хаан ххк						7			7
26	Натур хаан ХХК						7			7
27	Ийгл Бродкастинг ХХК						18	1		19
28	Очир роуд ХХК						1			1
29	Ашдын нөхөр ХХК			8			23			31
30	Улаанбаатар телевиз ХХК	4	2							6
Нийт 651 өөрийн бүтээл										


Өөрийн бүтээлийг хөтөлбөрийн төрлөөр нь авч үзэхэд “нэвтрүүлэг”-ийн төрөлд хамаарах бүтээлүүд нь 513 буюу 78.8% байгаа нь нийт бүртгэгдсэн өөрийн бүтээлийн хамгийн их хувийг эзэлж байна. Харин хүүхэлдэйн кино 1 бүртгэгдсэн нь бүтээлийн хамгийн бага хувийг буюу 0.1%-ийг эзэлж байна.

Нэвтрүүлгийн төрөлд хамаарах бүтээлийг хамгийн их бүртгүүлсэн үйлчилгээ эрхлэгч нь Очир Арвай төв ХХК бөгөөд 151 нэвтрүүлэг бүртгүүлсэн нь нийт нэвтрүүлгийн 29.4%-ийг эзэлж байна. Харин хамгийн бага нэвтрүүлэг бүртгүүлсэн үйлчилгээ эрхлэгч нь “Шинэ зураг” ХХК болон “Очир роуд” ХХК нар бөгөөд тус бүр 1 нэвтрүүлэг бүртгүүлсэн нь нийт бүртгүүлсэн өөрийн бүтээлийн 0.2%-ийг эзэлж байна.

Хүснэгт 3. Системд бүртгэлтэй өөрийн бүтээлийг хөтөлбөрийн төрлөөр нь авч үзэхэд, тоогоор

№	Хөтөлбөрийн төрөл	Бүтээлийн тоо
1	Уран сайхны кино	18
2	Олон ангит кино	42
3	Баримтат кино	12
4	Хүүхэлдэйн кино	1
5	Олон ангит хүүхэлдэйн кино	1
6	Нэвтрүүлэг	513
7	Богино хэмжээний кино	4
8	Бусад	60

График 2. Системд бүртгэлтэй өөрийн бүтээлийг хөтөлбөрийн төрлөөр нь авч үзэхэд, хувиар



Системд бүртгэлтэй өөрийн бүтээлүүдээс хамгийн их хувийг эзэлж байгаа нэвтрүүлгийн төрөлд хамаарах бүтээлүүд нь уран сайхны кино, хүүхэлдэйн кино бүтээх зардлаас хямд, хялбар тул телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн дийлэнх нь өөрийн редакцад нэвтрүүлэг бэлтгэн хүргэж байна. Энэ нь “нэвтрүүлэг”-ийн төрөлд хамаарах бүтээлүүдийн хувь хэмжээг нэмэгдүүлэхэд гол нөлөө үзүүлж байна.

2.2. ДОТООДЫН БҮТЭЭЛ: Тус системд дотоодын бүтээлээ бүртгүүлсэн үйлчилгээ эрхлэгчдийн тоо 2024 оны 2 дугаар улирлын байдлаар 12 байгаа нь системд бүртгэлтэй нийт үйлчилгээ эрхлэгчдийн 7%-тай тэнцэж байгаа бөгөөд өөрийн бүтээл бүртгүүлсэн үйлчилгээ эрхлэгчдээс 18-аар буюу 60%-иар бага үзүүлэлттэй байна. Системд эдгээр 12 үйлчилгээ эрхлэгчдийн нийт 446 дотоодын бүтээл байгаа нь нийт бүтээлийн 21%-ийг эзэлж байна. “Малчин удмын хийморь” ХХК нь 102 дотоодын бүтээл бүртгүүлсэн нь хамгийн их хувийг буюу нийт дотоодын бүтээлийн 22%-ийг эзэлж байгаа бол “Чаннел-Уан” ХХК нь 1 дотоодын бүтээл бүртгүүлсэн нь хамгийн бага хувийг буюу 0.2%-ийг эзэлж байна.




Хүснэгт 4. Системд бүртгэлтэй дотоодын бүтээлийг хөтөлбөрийн төрлөөр нь үйлчилгээ эрхлэгч нэг бүрээр авч үзэхэд

№	Үйлчилгээ эрхлэгчийн нэр	Уран Сайхны кино	Олон ангит кино	Баримтат кино	Хүүхэлдэйн кино	Олон ангит хүүхэлдэйн кино	Нэвтрүүлэг	Богино хэмжээний кино	Бусад	Нийт
1	Малчин удмын хийморь ХХК	95	1				2	3		101
2	Масс Ти Ви ХХК						4			4
3	Трионикс мета вишн ХХК	12								12
4	Суваг ти ви найм ХХК	3								3
5	Эн Ти Ви Бродкастинг ХХК	26	3				2			31
6	Фило ХХК	46		17	14		16			93
7	Юнайтед бродкастинг корпорэйшн ХХК								80	80
8	Ай Жи Би Ти Виз ХХК						7			7
9	Чаннел-Уан ХХК					1				1
10	Мичид Ньюс ХХК						4			4
11	Эм Ви Эс ХХК	59								59
12	Ори медиа ХХК	48	3							51
Нийт: 446 дотоодын бүтээл										

Дотоодын бүтээлээ системд бүртгүүлсэн үйлчилгээ эрхлэгчдийг үйлчилгээний төрлөөр нь авч үзэхэд олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч-1, өргөн нэвтрүүлгийн телевизийн үйлчилгээ эрхлэгч-8, арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэгч-3 байна. Дотоодын бүтээл бүртгүүлсэн үйлчилгээ эрхлэгчдийн нийт тоотой харьцуулахад ОСДҮЭ-8%, ӨНТҮЭ- 67%, АТҮЭ-25% байна.

График 3. Үйлчилгээ эрхлэгчдийн системд бүртгүүлсэн дотоодын бүтээлийг нийт дотоодын бүтээлд эзлэх хувиар авч үзэхэд






Хүснэгт 5. Системд бүртгэлтэй дотоодын бүтээлийг хөтөлбөрийн төрлөөр нь авч үзэхэд, тоогоор

№	Хөтөлбөрийн төрөл	Бүтээлийн тоо
1	Уран сайхны кино	289
2	Олон ангит кино	7
3	Баримтат кино	17
4	Хүүхэлдэйн кино	14
5	Олон ангит хүүхэлдэйн кино	1
6	Нэвтрүүлэг	35
7	Богино хэмжээний кино	3
8	Бусад	80

График 4. Системд бүртгэлтэй дотоодын бүтээлийг хөтөлбөрийн төрлөөр нь авч үзэхэд, хувиар



Дотоодын бүтээлийн санд 289 уран сайхны кино бүртгүүлсэн нь системд бүртгэлтэй байгаа нийт дотоодын бүтээлтэй харьцуулахад хамгийн их хувь буюу 65% байна. Үүнээс “Малчин удмын хийморь” ХХК 96 уран сайхны кино бүртгүүлж, нийт дотоодын бүтээлийн 32.6%-ийг эзэлж байгаа бол “Суваг ти ви найм” ХХК нь 3-г бүртгүүлсэн нь хамгийн бага хувийг буюу 1%-ийг эзэлж байна.

“Чаннел-Уан” ХХК нь 1 олон ангит уран сайхны кино бүртгүүлсэн нь дотоодын бүтээлийн санд хамгийн бага хувийг эзэлж байна.

2.3. ГАДААД БҮТЭЭЛ: Уг системд 17 үйлчилгээ эрхлэгчийн 1014 гадаадын бүтээл бүртгэгдсэн бөгөөд нийт бүтээлийн 48%-тэй тэнцэж байна. Үйлчилгээний төрлөөр нь авч үзэхэд өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгч-8, арилжааны телевизийн үйлчилгээ эрхлэгч-5, олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч-4 байна. Эдгээр үйлчилгээ эрхлэгчдийн тоог системд бүртгэлтэй нийт үйлчилгээ эрхлэгчдийн тоотой харьцуулахад 10%-тай тэнцэж байгаа бөгөөд өөрийн бүтээлээ бүртгүүлсэн үйлчилгээ эрхлэгчдийн тооноос 43%-иар бага, дотоодын бүтээл бүртгүүлсэн үйлчилгээ эрхлэгчдээс 29%-иар их үзүүлэлттэй байна.


“Фило” ХХК нь хамгийн их гадаадын бүтээл бүртгүүлсэн бөгөөд нийт бүртгүүлсэн гадаад бүтээлийн 24%-тай тэнцэж байгаа бол хамгийн бага гадаад бүтээл бүртгүүлсэн үйлчилгээ эрхлэгч нь “Эн Би Си” ХХК бөгөөд нийт бүртгүүлсэн гадаад бүтээлийн 0.2%-тай тэнцүү байна.



Хүснэгт 6. Үйлчилгээ эрхлэгчдийг системд бүртгүүлсэн гадаад бүтээлийг үйлчилгээ эрхлэгч нэг бүрээр авч үзэхэд

№	Үйлчилгээ эрхлэгчийн нэр	Уран Сайхны кино	Олон ангит кино	Баримтат кино	Хүүхэддэй кино	Олон ангит хүүхэддэй кино	Нэвтрүүлэг	Богино хэмжээний кино	Бусад	Нийт
1	Гэгээн далай ХХК		6		1	5				12
2	Ийгл Бродкастинг ХХК						4			4
3	Масс Ти Ви ХХК	8								8
4	Медиа холдинг ХХК						2			2
5	Мобинет ХХК		14				1			15
6	Монвсат нэтворк ХХК	231								231
7	Монголсат нэтворкс ХХК	48	8		44	5				105
8	Нэйшнл ньюс корпорэйшн ХХК						5			5
9	Трионикс мета вишн ХХК	59						1		60
10	Тэнгэрлэг эх орон ХХК	87	16			3	27			133
11	Фило ХХК	152	10	18	62	1	2			245
12	Чаннел-Уан ХХК	16	3		3		1			23
13	Шинэ сансар кабель ХХК	29								29
14	Эм Ви Эс ХХК	38								38
15	Эн Би Си ХХК	2								2
16	Эн Ти Ви Бродкастинг ХХК	42	35		2		6		10	95
17	Юнайтед бродкастинг корпорэйшн ХХК								7	7
Нийт: 1014 гадаад бүтээл бүртгэгдсэн										

График 5. Үйлчилгээ эрхлэгчдийн бүртгүүлсэн дотоодын бүтээлийг системд бүртгэлтэй нийт дотоодын бүтээлд эзлэх хувиар авч үзэхэд






Гадаад бүтээлийн тоог хөтөлбөрийн төрлөөр нь авч үзэхэд уран сайхны кино 712 бүртгэгдсэн нь нийт гадаад бүтээлийн 70%-тай тэнцэж байна. Уран сайхны киноны төрөлд “Монвсат нэтворк” ХХК нь хамгийн их хувийг бүрдүүлж байгаа ба нийт 231 кино бүртгүүлж, 32.4%-ийг эзэлж байна. Богино хэмжээний киноны төрөл нь нийт бүртгэгдсэн гадаад бүтээлийн хамгийн бага хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 7. Системд бүртгэлтэй гадаад бүтээлийг хөтөлбөрийн төрлөөр нь авч үзэхэд, тоогоор

№	Хөтөлбөрийн төрөл	Бүтээлийн тоо
1	Уран сайхны кино	712
2	Олон ангит кино	92
3	Баримтат кино	18
4	Хүүхэлдэйн кино	112
5	Олон ангит хүүхэлдэйн кино	14
6	Нэвтрүүлэг	48
7	Богино хэмжээний кино	1
8	Бусад	17

График 6. Системд бүртгэлтэй гадаад бүтээлийг хөтөлбөрийн төрлөөр нь авч үзэхэд, хувиар



Системд бүртгэлтэй гадаад бүтээлүүдийг эрх эзэмшигчийн харьяалах улсаар нь авч үзэхэд АНУ-ын бүтээлүүд хамгийн их хувийг бүрдүүлж байгаа бол Албани, Армени, Бельги, Дани, Канад, Малайз, Норвег, Филиппин, Швед, Шинэ Зеланд зэрэг улсын бүтээл тус бүр 1 бүртгэгдсэн нь хамгийн бага хувийг эзэлж байна.

Хүснэгт 8. Системд бүртгэлтэй гадаад бүтээлийг харьяалах улсаар нь авч үзэхэд, тоогоор


№	Эрх эзэмшигчийн харьяалал, улс	Гэгээн далай ХХК	Ийгл Бродкастинг ХХК	Масс Ти Ви ХХК	Медиа холдинг ХХК	Мобинет ХХК	Монвсат нэтворк ХХК	Монголсат нэтворк ХХК	Нэйшл Ньюс корпорэйшн ХХК	Трионикс мета вилш ХХК	Тэнгэрлэг эх орон ХХК	Фило ХХК	Чаннел-Уан ХХК	Шинэ сансар кабель ХХК	Эм Ви Эс ХХК	Эн Би Си ХХК	Эн Ти Ви Бродкастинг ХХК	Юнайтед бродкастинг корпорэйшн ХХК	Нийт
1	Албани							1											1
2	Австрали						1	5			2			1					9
3	Австри						1	1											2
4	Америк						97	10	5	7	4	214	1	20	12		9		379
5	Армени									1									1
6	Бельги							1											1
7	Бразил												1		3				4
8	Британи						2			4	7	1							14
9	Вьетнам						2												2
10	Герман		4					5			4								13
11	Дани							1											1
12	Иран									3									3



13	Испани					1			2				1				4		
15	Казахстан						1						1				2		
16	Канад						1										1		
17	Малайз						1										1		
18	Мексик											1	1				2		
20	Нидерланд					1	1										2		
21	Норвег						1										1		
22	Орос					5	7			7		2	6		2		29		
23	Румын								1	1							2		
24	Сингапур	3											1				4		
25	Солонгос	4		2		112	51		4	2	17		12		37		241		
26	Турк	1					1								1		3		
27	Украин						1						1				2		
28	Филиппин					1											1		
29	Франц					1	1		21	2	1						26		
30	Хятад					2	13		19	2	10	1	1				48		
31	Швед												1				1		
32	Швейцар									4							4		
33	Шинэ Зеланд					1											1		
34	Энэтхэг													2			2		
35	Япон					2	2		2	1	10	2	2				21		
36	Бусад	4		8		15	2				102				2	46	7	186	
	Нийт	12	4	8	2	15	231	105	5	60	133	245	23	29	38	2	95	7	1014

АНУ-ын бүтээл бүртгүүлсэн үйлчилгээ эрхлэгчдийг авч үзэхэд “Фило” ХХК нь 214 бүтээл системд бүртгүүлсэн нь хамгийн их хувийг бүрдүүлж, 56.4%-тай тэнцэж байна. Харин “Чаннел-Уан” ХХК нь 1 АНУ-ын бүтээл бүртгүүлсэн нь хамгийн бага хувийг бүрдүүлж байна.

График-7. Системд хамгийн их бүртгэгдсэн гадаад бүтээлийн харьяалах улс орныг нийт гадаад бүтээлд эзлэх хувиар авч үзэхэд.



Нийт гадаад улсын бүтээл бүртгүүлсэн үйлчилгээ эрхлэгчдийг үйлчилгээний төрлөөр нь авч үзэхэд: ОСДҮЭ нь БНСУ-33%, АНУ-20%, БНХАУ-10%, Герман-4%-тай бүртгүүлсэн бол арилжааны телевиз нь АНУ-35%, БНСУ-36%, Франц-7%, БНХАУ-21%-тай, ӨНТВ нь АНУ-44%, БНСУ-13%, БНХАУ-3%, Япон-3%-ийг тус тус системд бүртгүүлсэн байна.



Дүгнэлт

“Телевиз, олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн зохиогчийн эрхийн зөвшөөрөлтэй бүтээлийн жагсаалтыг ил тод, нээлттэй байршуулах дундын нэгдсэн систем”-д бүтээл оруулсан нийт 40 үйлчилгээ эрхлэгч байгаа бөгөөд үүнийг системд бүртгэлтэй бүтээлийн мэдээллээ оруулах шаардлагатай үйлчилгээ эрхлэгчийн тоонд харьцуулахад 29% (ОСДҮЭ-6, ӨНТВ-23, Арилжааны ТВ-11)-ийг эзэлж байна.

Системийн хэрэгжилтийг бид 3 үе шаттай эхлүүлсэн. Үүнд:

- 1. Үйлчилгээ эрхлэгчдийн мэдээллийг системд бүртгэх үйл явц:** Зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөлтэй 168 үйлчилгээ эрхлэгчийн ерөнхий мэдээллийг системд оруулж, үйлчилгээ эрхлэгчдийн мэдээллийг 100% бүртгэж дууссан.
- 2. Бүтээлийн мэдээллээ оруулах үйлчилгээ эрхлэгчдийн ажилтны мэдээллийг бүртгэх үйл явц:** Тус хорооны 2023.10.06-ны өдрийн 08/1393 тоот албан бичгийн хүрээнд үйлчилгээ эрхлэгчдээс системд бүтээлийн мэдээллээ оруулах ажилтны мэдээллийг авч, 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор үйлчилгээ эрхлэгч тус бүрд нэвтрэх эрхийг нь нээж өгсөн.
- 3. Үйлчилгээ эрхлэгчдийн бүтээлийн мэдээллээ оруулах үйл явц:** Тус хорооны 2024.03.12-ны өдрийн 08/372 тоот албан бичгээр бүх үйлчилгээ эрхлэгчдэд системийн мэдээллээ оруулах шаардлагыг хүргүүлсэн. Тус шаардлагын хүрээнд 40 үйлчилгээ эрхлэгч гадаад, дотоодын мэдээллээ системд бүртгүүлж 29%-ийн хэрэгжилттэй байна.

Системд бүртгэлтэй үйлчилгээ эрхлэгчдийн тоотой харьцуулахад дээрх тоон мэдээлэл нь хангалттай сайн үзүүлэлт биш хэдий ч албан ёсны эрхийг нь авсан контент, бүтээл, нэвтрүүлгийн жагсаалтыг өөрийн цахим хуудсандаа байршуулан олон нийтэд мэдээлж байгаа үйлчилгээ эрхлэгчдийн тоонд харьцуулбал 91%-иар илүү байна.

Түүнчлэн үйлчилгээ эрхлэгчид нь системд бүтээлийн мэдээллээ оруулах явц удаашралтай байгаа хэдий ч 2024 оны 2 дугаар улирлын байдлаар мөн оны 1 дүгээр улиралтай харьцуулахад 25%-ийн өссөн дүнтэй байна. Үүнээс үзэхэд үйлчилгээ эрхлэгчид нь тус системийг хэрэглэж хэвшиж байгаа нь харагдаж байна.

Мөн системд 31 ОСДҮЭ бүртгэлтэй байгаа ч өнөөдрийн байдлаар 2 үйлчилгээ эрхлэгч нь тусгай зөвшөөрлөө хүчингүй болгуулсан, технологийн онцлогоос шалтгаалан зөвхөн телевизийн суваг дахин дамжуулдаг, видео сангийн үйлчилгээ үзүүлдэггүй үйлчилгээ эрхлэгчид нь дийлэнх хувийг эзэлж байгаа бөгөөд энэ нь бүтээлийн мэдээллээ оруулсан үйлчилгээ эрхлэгчдийн хувь хэмжээнд нөлөөлж байна.

Цаашид Зохиогчийн эрхийн тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1, Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, хэт төвлөрөл үүсэхээс сэргийлэх журмын 2.8.3-т заасныг хангаж ажиллах талаар анхааруулж, бүтээлийн мэдээлэл оруулж байгаа үйлчилгээ эрхлэгчдийн тоог нэмэгдүүлж хэрэгжилтийг хангуулах, түүнчлэн үйлчилгээ эрхлэгчдийн хувьд тус системийн хэрэглээ, ач холбогдол ямар байгаа болон хэрхэн сайжруулж хэрэглээг нэмэгдүүлэх талаар санал асуулга явуулах шаардлагатай байна.